



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 05 өдөр

Дугаар Н/100

Хужирт сум


Ус ашиглуулах тухай

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь заалтыг үндэслэн  
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Тө-Ба-Сэ" ХХК-нд 2019 онд 6805.2 м<sup>3</sup>/жил халуун рашааныг эмчилгээний  
зориулалтаар ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. Ус ашиглах гэрээг байгуулж, төлөлтөнд нь хяналт тавьж ажиллахыг  
байгаль хамгаалагч Ч.Сонинбаяр, О.Алтанчимэг, Усны тухай хууль болон  
холбогдох журам стандартын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг байгаль орчны  
хяналтын улсын байцаагч З.Цэцэгмаа нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/101

Хужирт сум

Тууврын мал түр амраах, хоноглох  
цэг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 (а) дахь заалт, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолын “Мал амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтанд авах журам”-ын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Шунхлай 5 дугаар багийн Ширээ гэдэг газарт отор нүүдэл хийх, мал амьтны үзэсгэлэн худалдаа, нийтийг хамарсан уралдаан, хүнс, арилжаа наймаа, үржлийн зориулалтаар тээвэрлэх, тууварлах мал амьтныг түр амраах, хоноглох цэг болгон тогтоосугай.

2. Мал амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга хошууч (Х.Түмэнбаяр), Мал эмнэлгийн Улсын байцаагч (Б.Ичинхоролцэвэлмаа) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 19 өдөр

Дугаар A/102

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хархорин суманд зохион байгуулагдсан “Торгоны зам-Хархорум хот” аялал жуулчлал, соёлын арга хэмжээний зардалд 527300 (таван зуун хорин долоон мянга гурван зуун) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2019 оны 07 дугаар  
сарын 19 -ны өдрийн 1/02 дугаар  
захирамжийн хавсралт

“Торгоны зам-2019” арга хэмжээнд зарцуулсан зардал

№	Зардлын төрөл	Нэгжийн тоо	Нэгж ноогдох мөнгөн дүн	Нийт мөнгөн дүн
1	Тавгийн идээний хэвийн боов	44	2000	88000
2	Айраг	140	1900	266000
3	Бяслаг	3	15000	45000
4	Ааруул /сүүн хурууд/	2	25000	50000
5	Ааруул /хорхой/	2	15000	30000
6	Өрөм	3	7000	21000
7	Сүү	4 л	1200	4800
8	Хаяг /хулдаасан хэвлэл/	1,5 м	15000	22500
				<b>527 300</b>



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/103

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Мал эмнэлгийн үйлчилгээ ӨВХУСЗДТГ/201901019” бараа нийлүүлэгчийг сонгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Самдан - Мал аж ахуйн үйлдвэрлэл, технологи, үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Б.Ичинхоролцэвэлмаа - Мал эмнэлгийн Улсын байцаагч  
Б.Доржсэмбэ – Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

2. Гэрээ шууд байгуулах ажлыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээний төслийг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (С.Самдан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/104

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хийгдэх “Сумын төвийн камержуулалт”-ын ажлын явцад хяналт тавих, хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Самдан - Мал аж ахуйн үйлдвэрлэл, технологи, үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Д.Энхтүвшин - Засаг даргын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч  
Л.Цэдэв - Төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн  
Б.Ичинхоролцэвэлмаа- Мал эмнэлгийн Улсын байцаагч  
Б.Доржсэмбэ- Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

2. Дээрх ажлын явц, чанарт хяналт тавьж, гэрээний дагуу хүлээж авахыг ажлын хэсэгт, явцын талаар Засаг даргын дэргэдэх зөвлөлд танилцуулж байхыг ажлын хэсгийн ахлагч (С.Самдан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/105

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хийгдэх "Ерөнхий боловсролын сургуулийн анги танхимд камер, телевизор, уян камер" нийлүүлэх бараанд хяналт тавих, хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Самдан - Мал аж ахуйн үйлдвэрлэл, технологи, үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Л.Цэдэв - Төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн  
Б.Ичинхоролцэвэлмаа - Мал эмнэлгийн Улсын байцаагч  
М.Чимэдрэгзэн - Нярав  
Б.Жамъянсүрэн- Мэдээлэл зүйн багш

2. Дээрх ажлын явц, чанарт хяналт тавьж, гэрээний дагуу хүлээж авахыг ажлын хэсэгт, явцын талаар Засаг даргын дэргэдэх зөвлөлд танилцуулж байхыг ажлын хэсгийн ахлагч (С.Самдан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 05 өдөр

Дугаар A/106

Хужирт сум

Г Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай Г

“Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Засаг даргын 2005 оны “Газар өмчлүүлэх тухай” 71 дүгээр захирамжийн хавсралтын 57 дугаарт байгаа 1 өрхийн нэр бүхий 3 иргэний өөрсдийн гаргасан хүсэлт, газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээг үндэслэн хавсралтанд заасан нэр бүхий иргэдийн газар өмчлөх эрхийг шилжүүлсүгэй.

2. Газрыг тухайн гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлж, бусад гишүүдэд газрыг хууль тогтоомжид заасны дагуу нэг удаа үнэгүй өмчлүүлэх ажлыг зохион байгуулахыг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



Хужирт сумын Засаг даргын 2019 оны  
 8 дугаар сарын 5 ны өдрийн /106 дугаар  
 захирамжийн хавсралт

Газар өмчлөх эрхээ шилжүүлсэн иргэдийн нэрсийн жагсаалт

Эрхийн дугаар	Д/д	Өмчлөгчийн						Газрын				
		Овог	Эцэг /эх/-ийн нэр	Өөрийн нэр	Оршин суугаа хаяг	Регистр	16 нас хүрээгүй өмчлөгчийн гэрчилгээний дугаар	Урьд нь газар өмчлүүлсэн захирамжийн дугаар, огноо	Байр шил	Хэмжээ /м2/	Газрын үнэ /мян. төг/	
А	0	1	2	3	4	5	6	7	8	9	10	
5	1	Боржигин насчир	Жамъяндорж	Рапил	5-р баг	ЙС62102403						
5	2	Хар нүдэн	Алтанхуяг	Пагамсүрэн	1-р баг	ЙС91041805		2005.06.07	71	5-р баг	1191	600



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/107

Хужирт сум

□ Хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны □  
өвөлжилтийн бэлтгэл хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а" дахь заалт, Засгийн газрын 2019 оны "Хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" 285 дугаар тогтоолын 1-4, Аймгийн Засаг даргын 2019 оны 7 дугаар сарын 29-ны өдрийн "Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай" А/520 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, өвөлжилтийн бэлтгэл хангуулах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу сайтар зохион байгуулж, биелэлтийн үр дүнг 2019 оны 10 дугаар сарын 10-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Д.Мөнхбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2019 оны  
8 дугаар сарын 12-ны өдрийн 8 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт


ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ,  
ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Д.Мөнхбат - Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: С.Самдан - Мал аж ахуй, үйлдвэрлэлийн  
технологи, үржил, бүртгэл хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Б.Пүрэвжав - Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн  
Б.Пагамдулам 1 дүгээр багийн Засаг дарга  
Д.Батбаян 2 дугаар багийн Засаг дарга  
Д.Галиндэв 3 дугаа багийн Засаг дарга  
Д.Батбаяр 4 дүгээр багийн Засаг дарга  
Я.Осоржамаа 5 дугаар багийн Засаг дарга  
Ц.Амгалан 6 дугаар багийн Засаг дарга  
Э.Баасансүрэн Эрүүл мэндийн төвийн эрхлэгч  
А.Гантулга ЕБСургуулийн захирал  
З.Оюунчимэг 1 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгч  
Ш.Эрдэнэхорол 2 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч  
О.Долгормаа Соёлын төвийн эрхлэгч  
Ц.Тунгалаг Цаг уур өртөөний эрхлэгч  
Ч.Нэргүй "Хужирт илч" ХХК-ний захирал  
Ц.Туул "Шунхлай Ач" ХХК-ний захирал  
О.Базарсад "Монгол засвар" ХХК-ний захирал

Сумын Засаг даргын 2019 оны  
 2...-р сарын 12...-ны өдрийн 1/02-р  
 захирамжийн 2...-р хавсралт



**ХУЖИРТ СУМЫН 2019-2020 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН  
 БЭЛТГЭЛ ХАНГАХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ  
 ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хийх ажил	Хугацаа	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага.
<b>Нэг :Удирдлага зохион байгуулалтын талаар</b>		
1. Өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан бэлтгэл ажлыг хангах талаар зохион байгуулалтын нэгдсэн арга хэмжээ авч ажиллах, тайланг сар бүрийн 15-ны дотор ХХААГазарт хүргэх.	9, 10 дугаар сарын 15-ны дотор	ХАА-н тасгийн мэргэжилтэн С.Самдан
2. Төв суурингийн болон мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах, шалгах хүлээн авах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	09 дүгээр сарын 30-ны дотор	Засаг даргын орлогч Ж.Оюунгэрэл .
3. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх ажлыг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэж, холбогдох арга хэмжээг авч ажиллах	9,10-р саруудад	БЗДарга нар, ИТХ
4. Аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 96-р тогтоолоор баталсан “Сум дундын отрын бүс нутаг”-ийн бэлчээрийг хяналтандаа авч ажиллах, цаг хүндэрсэн үед отроор өвөлжих, хаваржих өрх, малын тоо судалгааг гаргаж, отроор мал оруулах боломж нөхцлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	2019-2020 онд	ХАА-н тасаг, БЗДарга нар
4. Малчид, мал бүхий иргэдийн түвшинд байгалийн хадлан болон гар тэжээл, бэлтгэх, өвөлжилтийн бэлтгэл хангах талаар уриалга, зөвлөмжийг хүргэж ажиллах	9 –р сард багтаан	ХАА-н тасаг
5. Малчдын хувийн бэлтгэлийг хангахад анхаарч цаг агаарын мэдээ, мэдээлэлийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон мессеж модем ашиглан тухай бүрд авч байх боломжийг бүрдүүлэх, сумын эрүүл мэндийн төвийн бэлэн байдлыг хангах , эм эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	Тухай бүрд	Цаг уурын эрхлэгч Ц.Тунгалаг, ЭМТөвийн эрхлэгч Э.Баасансүрэн ХАА-н тасаг

6.Сумын ажлын хэсэг өвөлжилтийн бэлтгэл хангалтын байдалтай газар дээр нь танилцаж айл өрх бүртэй танилцаж үнэлгээ дүгнэлт өгөх, бэлтгэсэн хадлан тэжээлийн мэдээг малчны нэрсээр гаргаж нэгтгэн бодитоор гаргах.	Тухай бүрд	БЗДарга нар, ХАА-н тасгийн мэргэжилтэн С.Самдан
<b>Хоёр: Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах талаар</b> 2.1 Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг хангах талаар		
1. Малчид мал бүхий иргэдээс бэлтгэх өвс хадлан, гар тэжээл, эрдэс тэжээлийн доод хэмжээг тухайн бүс нутгийн онцлог, зун зуншлагын байдал зэргийг харгалзан тогтоон өгч биелэлтэнд хяналт тавьж ажиллах	10-р сарын 15-ны дотор	БЗДарга нар, ХАА-н тасаг
2. Сумын тэжээл үйлдвэрийн цехүүдийн үйлдвэрийн аргаар бэлтгэсэн тэжээлийн нөөцийг нэмэгдүүлж, цехүүдийн үйл ажиллагааг жигдрүүлэх арга хэмжээ авч ажиллах.	11-р сарын 30-ны дотор	Сумын ЗДТГ,ХАа-н тасаг
3. Мал сүрэгт намрын ангилалтын ажлыг шуурхай зохион байгуулж хээлтүүлэгч малын хүрэлцээ хангамжийг судлан, стандартад тэнцсэн хээлтүүлэгчээр хангах, дутагдаж байгаа хээлтүүлэгчийг дотоодын цөм сүрэг болон, зохиомол хээлтүүлгийн үр дүнд гарсан өсвөр хээлтүүлэгчээр нөхөн хангах арга хэмжээ авах хуц, ухныг өвөл ялгаж тэжээх бэлтгэл хангасан байх	3, 4-р улиралд	ХАА-н тасаг, БЗДарга нар
4. Өвөл, хаврын бэлчээрийн даацад тулгуурлан аймаг дундын отрын бүс нутагт мал оруулж өвөлжүүлэх гэрээ байгуулах, байгалийн тусгай хамгаалалттай газруудад отроор өвөлжих, хаваржих өрх, малын тоог гарган холбогдох байгууллагаас зөвшөөрөл авч зохион байгуулах.	3,4-р улиралд	ХАА-н тасаг, БЗДарга нар
5. Отор нүүдлийг цаг алдалгүй хийж, малдаа тарга хүч авхуулан малд ангилалт үзлэг хийж дундаас доош тарга хүчтэй болон бэлчээрийн даацаас хэтэрсэн малыг зах зээлд борлуулаж эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлыг зохион байгуулах	Тухайн хугацаанд нь.	Сумын ЗДТГ
6. Бэлчээрийн хортон мэрэгч, оготонотой механик аргаар тэмцэх ажлыг малчдын өөрсдийн хүчээр зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх	10,11-р саруудад	Сумын ЗДТГ
7. Намрын графикт тарилга, туулгалт, угаалга, боловсруулалтыг технологийн хугацаанд нь хийж шаардлагатай мал сүргийг бүрэн хамруулах, өсвөр охин төлд /хурга, ишиг, тугал/ бруцеллёзын вакцин тарих	10-р сарын 15-ны дотор	ХАА-н тасаг, Гонир, Гуа харз МЭҮН
8. Малын хашаа саравчийг засаж, сэлбэх, шинээр барих замаар хүрэлцээ хангамжийг сайжруулах, шавж дулаалах, хэвтэр бууцыг	09, 10-р сард	БЗДарга нар, Малчид

хатаах, хэрзэн ховхлох, ариутгаж халдваргүйжүүлэх		
<b>Гурав.Төв суурингийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах талаар</b>		
1.Сумын албан байгууллагын дулааны эрчим хүч үйлдвэрлэх зуухнуудад 2019.10.01-ны дотор 20-иос доошгүй хоногийн нүүрсний нөөцтэй болох	10-р сарын 01-ны дотор	Хужирт илч ХХК, Монгол засвар ХХК, Шунхлай ач ХХК
2.Аж ахуйн нэгжүүдийг нөөцийн бага оворын цахилгааны эх үүсгэвэртэй болгох талаар холбогдох арга хэмжээ авах	10-р сарын 01-ны дотор	Сумын ЗДТГ, Хужирт илч ХХК, Монгол засвар ХХК Шунхлай ач ХХК
3.ЕБС, СӨББ, ЭМТ, Рашаан сувилал, аж ахуйн нэгжүүдийн өвөлжилтийн бэлтгэл хангах, төлөвлөгөө гарган биелэлтэд нь хяналт тавьж ажиллах	10-р сарын 15-ны дотор	ААН, Байгууллага бүр
4.Албан байгууллагуудын ажлын байрны дулаалгыг чанартай хийлгэн хүлээн авах ажлыг зохион байгуулах	10-р сарын 05-ны дотор	Ажлын хэсэг



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/108

Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний  
хугацааг сунгах тухай

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Шивээт 4 дүгээр багийн иргэн Алтангэрэлийн Лувсаншаравын (ИС61012016) эзэмшлийн 4 дүгээр багийн Шивээт 10-4 тоотод байрлах 0011158 эзэмшлийн гэрчилгээний дугаартай, 6211003173 нэгж талбарын дугаартай худалдаа үйлчилгээний зориулалттай 595 м<sup>2</sup> газрын эзэмших эрхийг 40 жилийн хугацаатайгаар сунгаж үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох, газрын улсын бүртгэлд өөрчлөлт хийхийг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 27 өдөр

Дугаар 4/109

Хужирт сум


Бруцеллэз өвчнөөс урьдчилан  
сэргийлэх вакцинжуулалтын ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 (а), Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 3.3.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулахыг "Гонир манал", "Гуахарз" мал эмнэлэг үржлийн нэгжийн эмч (Ш.Байгальмаа), (Ц.Батдэлгэр) нарт тус тус даалгасугай.

2. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, тарилгын акт жагсаалтанд дүгнэлт гарган тайлан мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэхийг Мал эмнэлгийн хяналтын Улсын байцаагч (Б.Ичинхоролцэвэлмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/110

Хужирт сум

Малын генетик нөөцийн төлөв байдлыг  
тодорхойлох, үнэлэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын "Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлыг санхүүжүүлэх тухай" 2019 оны А/133 дугаар тушаалын 3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2019 оны "Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх тухай" А/423 дугаар захирамжийн 3 дахь заалт, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2019 оны 07 дугаар сарын 24-ний "Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх тухай" А/11 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн санхүүжилтээр сумын нийт 3363 толгой малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлыг 2019 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 10 дугаар сарын 1-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Самдан - Мал аж ахуйн үйлдвэрлэл, технологи, үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Б.Доржсэмбэ - Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Т.Даваадорж - 1 дүгээр багийн Засаг дарга

Д.Батбаян - 2 дугаар багийн Засаг дарга

Д.Галиндэв - 3 дугаар багийн Засаг дарга

Д.Батбаяр - 4 дүгээр багийн Засаг дарга

Я.Осоржамаа - 5 дугаар багийн Засаг дарга

Ц.Амгалан - 6 дугаар багийн Засаг дарга

3. Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох үнэлэх ажлыг чанартай зохион байгуулж тайлан мэдээг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (С.Самдан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 27 өдөр

Дугаар A/111

Хужирт сум

Ус ашиглуулах тухай

Монгол улсын Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “АЖУДС”-ийн харъяа “Газарчин хужирт” амралт сувилал ХХК-д 2019 онд 1542м<sup>3</sup>/жил халуун рашааныг эмчилгээний зориулалтаар ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. Ус ашиглах гэрээг байгуулж, төлөлтөнд нь хяналт тавьж ажиллахыг байгаль хамгаалагч Ч.Сонинбаяр, О.Алтанчимэг, Усны тухай хууль болон холбогдох журам стандартын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг байгаль орчны хяналтын улсын байцаагч З.Цэцэгмаа нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/112

Хужирт сум

Ус ашиглуулах тухай

Монгол улсын Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хужирт тур” ХХК-д 2019 онд 7240м<sup>3</sup>/жил халуун рашааныг эмчилгээний зориулалтаар ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. Ус ашиглах гэрээг байгуулж, төлөлтөнд нь хяналт тавьж ажиллахыг байгаль хамгаалагч Ч.Сонинбаяр, О.Алтанчимэг, Усны тухай хууль болон холбогдох журам стандартын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг байгаль орчны хяналтын улсын байцаагч З.Цэцэгмаа нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/113

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 1 дүгээр Цэцэрлэгийн түүхт 60 жилийн ойг тохиолдуулан олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа тус байгууллагын нэр бүхий 3 багш, ажилчдыг шагнаж урамшуулахад 900000 (ерэн мянган) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2019 оны  
9 дугаар сарын 19-ны өдрийн 13 дүгээр  
захирамжийн хавсралт

№	ОВОГ НЭР	АЛБАН ТУШААЛ	МӨНГӨН ДҮН
1	Рэнцэнгийн Оюунчимэг	Гал тогооны туслах	30000
2	Бийлхүүгийн Цэцэг-Эрдэнэ	Гал тогооны угаагч	30000
3	Борхүүгийн Алдарсүрэн	Тогооч	30000
<b>НИЙТ</b>			<b>90 000</b>

-oOo-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/114

Хужирт сум

Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

“Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Засаг даргын 2005 оны “Газар өмчлүүлэх тухай” 88 дугаар захирамжийн хавсралтын 121 дугаарт байгаа 1 өрхийн нэр бүхий 4 иргэний өөрсдийн гаргасан хүсэлт, газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээ гүндэслэн хавсралтанд заасан нэр бүхий иргэдийн газар өмчлөх эрхийг шилжүүлсүгэй.

2. Газрыг тухайн гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлж, бусад гишүүдэд газрыг хууль тогтоомжид заасны дагуу нэг удаа үнэгүй өмчлүүлэх ажлыг зохион байгуулахыг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ

Хужирт сумын Засаг даргын 2019 оны  
9 дугаар сарын 28 -ны өдрийн /11/ дугаар  
захирамжийн хавсралт

Газар өмчлөх эрхээ шилжүүлсэн иргэдийн нэрсийн жагсаалт

Өрхийн дугаар	Д/д	Өмчлөгчийн							Газрын		
		Овог	Эцэг /эх/- ийн нэр	Өөрийн нэр	Оршин суугаа хаяг	Регистр	16 нас хүрээгүй өмчлөгчийн гэрчилгээний дугаар	Урьд нь газар өмчлүүлсэн захирамжийн дугаар, огноо	Байршил	Хэмжээ /м2/	Газрын үнэ /мян.төг/
A	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
121	1	Боржигин	Дорж	Соёл	УБ.СБД	Ц379110663					
	2	Бурхан	Чулуунхүү	Ганцроож	УБ.СБД	ЙС99080150		2005.09.12	88	4-р баг	770
	3	Бурхан	Зургаанжин	Чулуунхүү	4-р баг	ЙС80051010					554400



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 4/115

Хужирт сум


Д.Мөнхбатын цалинг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоолын хавсралт, 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай” 277 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын дарга Дашнямын Мөнхбатын албан тушаалын цалинг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Д.Мөнхбатын албан тушаалын шинэчлэгдсэн цалинг 2019 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тооцож Засаг даргын Тамгын газрын цалингийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБАТ



Сумын Засаг даргын 2019 оны  
 2-дугаар сарын 23-ны өдрийн 2-дугаар  
 захирамжийн хавсралт

Д/д	Овог нэр	Албан тушаал	Албан тушаалын ангилал	Үндсэн цалин	Онцгой нөхцөл /хувь/	Төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдэл /хувь/	Зэрэг дэвийн нэмэгдэл /хувь/	Нууц /хувь/	Ажилласан хариуцсан хувь/	дүн
1	Д.Мөнхбат	Засаг даргын Тамгын газрын дарга	T3-9-4	920953		10	13	30	20	1.593.249

oOo



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/116

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн ажлын хэсэг суманд ирж ажилласантай холбогдуулан байр, хоолны зардалд 526000 (таван зуун хорин зургаан мянган) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2019 оны 9 дугаар  
сарын 24-ны өдрийн 116 дугаар  
захирамжийн хавсралт

Архивын үзлэг

№	Зардлын төрөл	Нэгжийн тоо	Нэгж ноогдох мөнгөн дүн	Нийт мөнгөн дүн
1	Байрны зардал	5	40000	200000
2	Мах	35	5000	175000
3	Бяслэг	5	10000	50000
4	Ааруул	5	12000	60000
5	Өрөм	5	8200	41000
				<b>526 000</b>

-оОо-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/117

Хужирт сум

Цэрэг татлагын комисс томилох тухай

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. 2019 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын үйл ажиллагааг зохион байгуулах комиссыг нэгдүгээр хавсралтаар, ажил үүргийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Цэрэг татлагыг 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж, тайланг 2019 оны 10 дугаар сарын 14-ний өдөр танилцуулахыг комиссын ахлагч (Д.Мөнхбат)-д даалгасугай.
3. Цэрэг татлагын үеэр зарцуулагдах хөрөнгийг тооцож, Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2019 оны  
9 дугаар сарын 27-ны өдрийн 117 дүгээр  
Захирамжийн нэгдүгээр хавсралт



Цэрэг татлагын комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга: Д.Мөнхбат - Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Х.Түмэнбаяр - Цагдаагийн тасгийн дарга

Ч.Байгалмаа - Нийгмийн даатгалын тасгийн дарга

Л.Цэдэв - Төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн

Т.Даваадорж - 1 дүгээр багийн Засаг дарга

Д.Батбаян - 2 дугаар багийн Засаг дарга

Д.Галиндэв - 3 дугаар багийн Засаг дарга

Д.Батбаяр - 4 дүгээр багийн Засаг дарга

Я.Осоржамаа - 5 дугаар багийн Засаг дарга

Ц.Амгалан - 6 дугаар багийн Засаг дарга

Т.Элбэгсайхан - Архив, бичиг хэргийн эрхлэгч

Э.Баасансүрэн - Эрүүл мэндийн төвийн эрхлэгч


Ц.Базарваань - Хэв журмын цагдаа

О.Долгормаа - Соёлын төвийн эрхлэгч

Г.Оюунмандах - Нягтлан бодогч

Ц.Жавхлантөгс - Насан туршийн боловсролын арга зүйч

Сумын Засаг даргын 2019 оны  
 9 дугаар сарын 17-ны өдрийн 1/Н дүгээр  
 захирамжийн хоёрдугаар хавсралт



Хужирт сумын 2019 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлага явуулах комиссын  
 гишүүдийн ажил үүргийн хуваарь

№	Нэр	Эрхэлсэн ажил	Хийж гүйцэтгэх ажил	Хугацаа
1	Д.Мөнхбат	ЗДТГ-ын дарга, Комиссын дарга	Цэрэг татлагын ажлыг удирдлагаар хангах, удирдан зохион байгуулах бэлтгэл ажлыг хангуулах, ажлын тайлан нэгтгэх	2019.10.10 2019.10.11
2	Л.Цэдэв	Төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн	Цэрэг татлагатай холбогдолтой бичиг баримт хөтлөх бүрдүүлэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах, тэмдэглэл хөтлөх	2019.10.10 2019.10.11
3	Т.Элбэгсайхан	Нарийн бичгийн дарга	Цэрэг татлагатай холбогдолтой бичиг баримт хөтлөн бүрдүүлэх.	2019.10.10 2019.10.14
4	Багийн Засаг дарга нар	Гишүүд	Цэргийн албанд татагдах эрчүүдийн нэрсийн жагсаалт гарган бүртгэлийн дагуу зарлан дуудах хуудсыг хүн бүрт хүргэн гарын үсэг зуруулан зарлан дуудах хуудасны тооцоо хийх	2019.10.10 2019.10.11
5	Э.Баасансүрэн	Эрүүл мэндийн эрхлэгч	Цэргийн комиссын эрүүл мэндийн үзлэг явуулах нөхцөл хангах, цэргийн насны эрчүүдийг эрүүлжүүлэх талаар хийсэн ажлын тайлан гаргах.	2019.10.10 2019.10.11
6	Г.Оюунмандах	Нягтлан бодогч	Цэрэг татлагатай холбогдон гарах зардлыг төсөвт тусгагдсаны дагуу гаргах, хяналт тавих	Цэрэг татлагын хугацаанд
7	Ц.Цэндхорлоо	Нярав	Цэрэг татлага явагдах байр бэлтгэх, эмх цэгцтэй цэвэр байлгах, аж ахуйн бүхий л асуудлыг хариуцах	Цэрэг татлагын хугацаанд
8	О.Долгормаа	Соёлын төвийн эрхлэгч	Холбоо үзлээр үйлчилэх, байрны цэвэр байдлыг хангуулах	2019.10.10 2019.10.11
9	Нийгмийн даатгалын байцаагч нар	Нийгмийн даатгалын байцаагч нар	Цэргийн комиссоор орох эрчүүдийн эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын дэвтэртэй болгох	2019.10.10 2019.10.11



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/118

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

